

## Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт оюутны тогтолцооны тойм

### Гадаад оюутан хүлээн авах тогтолцооны тойм

Япон Улсын гадаад оюутны харилцаа нь 1901 онд Боловсролын яамны тушаалаар гадаад оюутан хүлээн авах тогтолцоог бий болгосноос хойш 100 гаруй жилийн түүхтэй. Засгийн газрын тэтгэлэгт оюутныг 1954 оноос хүлээн авч эхэлсэн бөгөөд, 1974 онд Монгол, Япон хоёр улсын хооронд байгуулагдсан Соёлын харилцааны хэлэлцээрт үндэслэн 1976 онд Монголоос анхны Засгийн газрын тэтгэлэгт оюутныг хүлээн авсан.

2014 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Японд улсад Японы засгийн газрын болон хувийн зардлаар суралцаж буй гадаад оюутнуудыг нийт тоо 184,155-д хүрчээ.

### Японд суралцаж буй монгол оюутнуудын тоо

2014 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Японд суралцаж буй монгол оюутнуудын тоо 1,548-д хүрсэн байна. Энэхүү тоо нь Японд суралцаж байгаа бүх гадаад оюутнуудыг улс, бүс нутгаар нь ангилаж үзсэн тоогоор 11 дүгээрт орно. Мөн Японд суралцах боломжийн хувьд тухайн улсын иргэн 10,000 тутамд эзэмших гадаад оюутнуудын тооны хувь хэмжээг авч үзвэл, тус улсын иргэнээс Японд суралцагчдийн тоо нь 5.34 болж 1 дүгээрт орж байна.

Хүснэгт 1. Японд суралцах боломж (Тухайн улсын 10000 хүн ам тутамд ногдох Японд суралцагчийн тоо)

	Оюутны тоо	Өмнөх жилд	Хувь	10000 хүн ам тутамд ногдох Японд суралцагчийн тоо*	Хүн ам (сая)
Хятад	81,884	94,399	51.3%	0.67	1,401.7
Вьетнам	26,439	13,799	14.4%	2.86	92.5
БНСУ	15,777	17,283	8.6%	3.18	49.5
Непал	10,488	5,807	5.7%	3.73	28.1
Тайвань	6,231	5,660	3.4%	2.70	23.1
Тайланд	2,250	2,876	1.8%	0.48	67.2
Индонези	3,188	2,787	1.7%	0.13	252.8
Малайз	2,475	2,378	1.3%	0.82	30.2
Америк	2,152	2,275	1.2%	0.07	322.6
Мьянмар	1,935	1,598	1.1%	0.36	53.7
<b>Монгол</b>	<b>1,548</b>	<b>1,402</b>	<b>0.8%</b>	<b>5.34</b>	<b>2.9</b>



\* JASSO (Оюутныг дэмжих Японы байгууллага)-ын “Гадаад оюутан хүлээн авсан байдлын хураангуй – 2013”, НҮБ-ын Хүн амын сангийн “Дэлхийн хүн амын цагаан ном – 2013”-ын тоо баримтад үндэслэн тус ЭСЯ-наас тооцоолон гаргав.

### Монгол оюутны тооны өөрчлөлт

Монгол оюутныг хүлээн авах тоо ардчилал хөгжсөнөөс хойш эрс өсөж байгаа ба улсын болон хувийн зардлаар суралцаж буй оюутнуудын тоо аль аль нь тасралтгүй өссөөр байна. (Хүснэгт 2., График 1.-ийг үзнэ үү.)

Хүснэгт 2., График 1. Японд суралцагч монгол оюутны тооны өөрчлөлт

Он	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Оюутны тоо	15	19	27	53	84	117	159	188	308	284	342	389	544	714	806	924	1006	1110	1145	1215	1282	1170	1114	1402	1548



Японд суралцаж буй Монгол оюутны тоо

Японы Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлдэг бүх хөтөлбөрийн дагуу Монгол оюутан хүлээн авдаг бөгөөд 2014 онд 68 оюутныг хүлээн авч байна. (Хүснэгт 3.-ыг үзнэ үү.)

Хүснэгт 3. Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж буй монгол оюутны тоо, түүний өөрчлөлт (Судлаач болон Япон хэл, соёл судлаач оюутны их сургуулиас нэр дэвшигчийг багтаасан болно):

Японд очсон он	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
<b>Хөтөлбөр</b>												
Их сургуулийн үндсэн оюутан	18	16	22	21	14	13	23	16	8	12	7	5
Техникийн коллеж	9	10	11	16	14	15	18	21	15	18	18	15
Мэргэжлийн сургууль	7	5	5	4	7	4	5	4	3	2	4	1
Судлаач оюутан	12	20	20	22	22	23	27	21	9	26	24	38
Япон хэл, соёл судлаач оюутан	10	10	9	12	4	7	3	3	1	7	4	5
Багшийн мэргэжил дээшлүүлэх оюутан	3	3	3	3	3	3	3	3	3	4	2	0
Залуу удирдагч хөтөлбөр	3	4	2	5	2	5	3	2	1	2	2	4
<b>Нийт</b>	<b>73</b>	<b>68</b>	<b>72</b>	<b>83</b>	<b>66</b>	<b>67</b>	<b>82</b>	<b>70</b>	<b>40</b>	<b>71</b>	<b>61</b>	<b>68</b>

## *Засгийн газрын тэтгэлэгт оюутны хөтөлбөрүүдийн хураангуй*

### - Их сургуулийн үндсэн оюутан:

1 жил бэлтгэл сургуульд суралцсаны дараа Японы их, дээд сургуулийн үндсэн оюутнаар элсэн орох шалгалтыг өгсний үндсэн дээр 4 жил суралцан баклаврын зэрэгтэй төгсөнө. Анагаах болон шүд судлалын чиглэлээр бол бэлтгэл сургуульд 1 жил, үндсэн факультетэд 6 жил суралцана. Японы их, дээд сургуулийн хүлээн авах боломжтой бүх салбарт элсэлт авдаг.

### - Техникийн коллежийн оюутан:

Мэргэжлийн гүнзгий мэдлэгийг зааж, ажилд хэрэгтэй ур чадвар эзэмшүүлдэг техникийн коллежид суралцуулдаг. 1 жил бэлтгэл сургуульд суралцсаны дараа 3 жил суралцана. Дараах чиглэлээр элсэлт авдаг. Үүнд: Бодис, хүрээлэн буй орчин, Цахилгаан, электроник, Мэдээлэл, холбоо, харилцаа, Барилга, зам гүүр, Худалдааны онгоц, Бусад.

### - Мэргэжлийн сургуулийн оюутан:

Практик мэргэжлийн сургалт, технологийн сургалт явуулдаг мэргэжлийн сургуульд суралцуулдаг. 1 жил бэлтгэл сургуульд суралцсаны дараа 2 жил суралцдаг. Зам гүүр, Архитектур, Цахилгаан, Электроник, Цахилгаан холбоо, Хүнсний тэжээл судлал, Сургуулийн өмнөх насны сурган хүмүүжил, Нарийн бичиг, Зочид буудал, Дизайн, Аялал жуулчлал, Хувцас чимэглэл, Зураг, Бусад гэсэн чиглэлээр элсэлт авдаг.

### - Судлаач оюутан:

Японы их дээд сургуульд судлаач оюутнаар 1 жил хагасаас 2 жил суралцдаг. Япон хэлний мэдлэг байхгүй хүн үүний 6 сард нь япон хэлний бэлтгэл хийнэ. Тодорхой заагдсан хугацаанд магистрантур, доктрантурын шалгалтанд тэнцвэл тэтгэлэгийг сунгах боломжтой. Японы их, дээд сургуулийн хүлээн авах боломжтой бүх салбарт элсэлт авдаг.

### - Япон хэл, соёл судлаач оюутан:

Гадаадын их, дээд сургуульд япон хэл, соёлоор голлон мэргэшиж буй оюутан Японы их, дээд сургуульд ижил мэргэжлээр 1 жил суралцана.

### - Багшийн мэргэжил дээшлүүлэх оюутан:

ЕБС-д одоо багшилж буй багш Японы их, дээд сургуулийн багшийг сургах факультетэд 1 жил хагас тусгай дадлагад хамрагддаг. Япон хэлний зохих мэдлэггүй хүмүүс энэ хугацааны 6 сард нь япон хэлний бэлтгэл хийнэ.

### - Залуу удирдагч хөтөлбөр:

Засаг захиргаа, орон нутгийн засаг захиргаа, эрүүл мэндийн удирдлага, бизнес, хуулийн мэргэжлээр засаг захиргааны байгууллагад ажиллаж буй ажлын туршлагатай хүн Японы магистрантурт 1 жил суралцаж магистрын зэрэг авах бөгөөд бүх хичээлийг англи хэлээр үзнэ.

\* \* \*

## *Японд суралцах тухай мэдээлэл авах:*

Японд суралцах тухай бүх талын мэдээ мэдээлэл: STUDY IN JAPAN

<http://www.studyjapan.go.jp/en/index.html>

## *Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт оюутны тогтолцоо:*

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам:

<http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/kokuhiryugakumn.html#1>

*Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр:* JICE-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар,

<http://ids-scholarship.org/country/mongolia/>

[http://sv2.jice.org/e/ids\\_pro/mongol.htm](http://sv2.jice.org/e/ids_pro/mongol.htm)

*Хувийн зардлаар суралцах:* Оюутныг дэмжих Японы байгууллага (JASSO)

[http://www.jasso.go.jp/study\\_j/sgtj.html](http://www.jasso.go.jp/study_j/sgtj.html) (Японхэлээр)

[http://www.jasso.go.jp/study\\_j/index\\_e.html#a](http://www.jasso.go.jp/study_j/index_e.html#a) (Англи хэлээр)